

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалт хөгжлийн төв”-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/255/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,

тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Утас: 261663

Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цогбаяр

Утас: 261815

Цахим хаяг: tsogbayar.a@audit.gov.mn

Ахлах аудитор/аудитор: С.Болортуяа

Утас: 261815

Цахим хаяг: bolortuya@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: “Пийк ОМ Аудит” ХХК-ийн

Захирал Б.Жаргалсайхан

Утас: 99862066 Цахим хаяг: peakomauditllc@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

САГ-2026/255/НА-СТА-ТШЗ

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	20
4.1 Ерөнхий зүйл	20
4.2 Материаллаг байдал.....	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	20
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	21
4.5.1 Завсрын аудитын талаар	21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	23
5.2 Албан шаардлага.....	23
5.3 Зөвлөмж	25
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	26

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГБХНХЯ	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ХАРААГҮЙ ХҮМҮҮСИЙН ХӨДӨЛМӨР,
СУРГАЛТ, ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
З.ЛХАГВАСҮРЭН ТАНАА

2026.02.25 № 06/426
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт, хөгжлийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу дагуу хараат бусаар гүйцэтгэж гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 88,558.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Тайлант онд 62,042.4 мянган төгрөгийн түүхий эд материалын шууд худалдан авалт хийж, өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.
- Бараа материалын дансанд бүртгэлтэй ашиглалтын шаардлага хангахгүй, технологийн хоцрогдолд орсон нийт 23,624.2 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байгаа зэрэг зөрчлүүд илэрсэн.

Эдгээр зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1, 35.1.1, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Толилуулга” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол улсын Засгийн газраас 2025 оныг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил болгосонтой холбоотойгоор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хөрөнгө оруулалтаар 1,220,112.9 мянган төгрөгийн их засвар, 1,937,873.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 195,720.4 мянган төгрөгийн компьютер техник хэрэгсэл, нийт 3,353,707.1 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй нийлүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд өмнөх оны давсан орлогын авлагаас санхүүжсэн 17,728.9 мянган төгрөгөөс, тавилга эд хогшилд 7,728.00 мянган төгрөг, түүхий эд бараа материал худалдан авахад 10,000.00 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 0.9 мянган төгрөгийг улсын төсөв төвлөрүүлсэн байна.

Бусад асуудал

Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт, хөгжлийн төв 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 14 зорилтын хүрээнд 57 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгаснаас биелэлтийг хэрэгжилтийн дундаж хувь 85.1 гэж дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *B. А. Ц. НАРАНЧИМЭГ*



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	180,741,219.09	239,276,540.40
33	АВЛАГА	64,243,600.00	36,551,900.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	80,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	17,728,900.00	-
33500	Бусад авлага	46,514,700.00	36,471,900.00
33510	Байгууллагаас авах авлага	-	658,900.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	46,514,700.00	35,813,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	116,497,619.09	202,724,640.40
35100	Түүхий эд материал	14,688,920.00	54,212,170.00
35110	Тусгай зориулалттай материал	14,688,920.00	54,212,170.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	23,581,808.09	59,445,594.40
35300	Бэлэн бүтээгдэхүүн	33,371,504.00	49,346,881.00
35400	Хангамжийн материал	44,855,387.00	39,719,995.00
35420	Аж ахуйн материал	6,673,010.00	4,998,308.00
35470	Бусад хангамжийн материал	38,182,377.00	34,721,687.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,206,920,024.00	9,167,736,852.81
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,206,920,024.00	9,167,736,852.81
39200	Биет хөрөнгө	5,829,419,830.85	8,790,504,326.21
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,862,825,692.91	8,082,938,689.91
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,197,653,243.94)	(1,413,458,153.89)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	46,000,000.00	46,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(4,472,222.23)	(12,138,888.91)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	169,395,815.00	2,306,177,461.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(52,079,615.93)	(238,699,459.15)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,992,175.00	27,452,253.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,588,769.96)	(7,767,575.75)
39300	Биет бус хөрөнгө	377,500,193.15	377,232,526.60
39301	Програм хангамж	1,111,000.00	1,111,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(740,666.85)	(1,008,333.40)
39303	Бусад биет бус хөрөнгө	377,129,860.00	377,129,860.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	6,387,661,243.09	9,407,013,393.21
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,387,661,243.09	9,407,013,393.21
51	Засгийн газрын хувь оролцоо	6,387,661,243.09	9,407,013,393.21
51100	Засгийн газрын оруулсан капитал	5,959,596,819.84	5,959,596,819.84
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	5,959,596,819.84	5,959,596,819.84
51200	Хуримтлагдсан үр дүн	(1,209,130,366.95)	1,810,221,783.17
51210	Өмнөх үеийн үр дүн	(979,338,439.06)	(1,209,130,366.95)
51220	Тайлант үеийн үр дүн	(229,791,927.89)	3,019,352,150.12
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,637,194,790.20	1,637,194,790.20

“Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалт хөгжлийн төв”-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	6,387,661,243.09	9,407,013,393.21
---	--	------------------	------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,779,989,288.00	5,275,868,714.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	359,841,488.00	5,275,868,714.00
120	Нийтлэг татварын бус орлого	359,841,488.00	3,641,646,614.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	243,759,350.00	205,021,059.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	243,759,350.00	205,021,059.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	116,082,138.00	3,365,460,755.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	71,164,800.00
122	Тусламжийн орлого	-	1,634,222,100.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	1,634,222,100.00
12212	Харъяа төсвийн байгууллагаас төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн орлого	-	1,634,222,100.00
122122	Төсвийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн орлого	-	1,634,222,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,420,147,800.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,402,418,900.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,402,418,900.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17,728,900.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	17,728,900.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,009,781,215.89	2,256,516,563.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,009,781,215.89	2,256,516,563.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,945,416,191.77	2,191,157,729.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,140,784,450.83	1,328,484,042.69
210101	Үндсэн цалин	821,942,681.00	963,626,624.00
210102	Нэмэгдэл	192,299,296.83	187,640,697.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	126,542,473.00	177,216,721.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	126,837,837.28	149,088,546.06
210201	Тэтгэврийн даатгалын зардал	99,927,391.45	117,027,104.35
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	11,459,081.83	13,727,554.12
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	8,899,716.00	9,517,407.64

“Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалт хөгжлийн төв”-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	895,067.00	1,763,297.59
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	5,656,581.00	7,053,182.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84,185,399.92	80,291,801.43
210301	Гэрэл, цахилгаан	49,347,379.53	48,665,869.50
210302	Түлш, халаалт	14,236,082.13	15,998,982.45
210303	Цэвэр, бохир ус	20,601,938.26	15,626,949.48
2104	Хангамж, бараа материалын зардал	13,177,200.00	9,334,460.00
210401	Бичиг хэрэг	1,904,800.00	385,100.00
210402	Тээвэр, шатахуун	1,962,000.00	408,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	316,800.00	1,984,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,570,370.00	1,275,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,423,230.00	5,281,760.00
2105	Нормативт зардал	7,848,000.00	1,846,990.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,848,000.00	1,846,990.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	47,482,070.00	6,220,480.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,099,850.00	1,524,850.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	2,200,000.00
210604	Урсгал засвар	31,382,220.00	2,495,630.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,244,325.00	788,020.00
210803	Даатгалын үйлчилгээ	511,000.00	539,720.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	44,500.00	104,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	558,000.00	144,000.00
210807	Газрын төлбөр	5,130,825.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	518,856,908.74	615,103,388.97
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	281,579,806.27	199,565,496.78
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	237,277,102.47	415,537,892.19
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	64,365,024.12	65,358,834.73
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	40,341,153.40
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	40,341,153.40
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	40,341,153.40
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	40,340,253.40
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,520,312.00	25,017,681.33
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,077,912.00	24,621,681.33

“Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалт хөгжлийн төв”-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,442,400.00	396,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	33,844,712.12	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	33,843,693.12	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,019.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(229,791,927.89)	3,019,352,150.12
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	(229,791,927.89)	3,019,352,150.12

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,816,872,780.00	1,866,934,859.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	243,759,350.00	1,866,934,859.00
120	Нийтлэг татварын бус орлого	243,759,350.00	214,983,859.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	243,759,350.00	214,983,859.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	243,759,350.00	214,983,859.00
122	Тусламжийн орлого	-	1,651,951,000.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	1,651,951,000.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	1,634,222,100.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	1,634,222,100.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	17,728,900.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	17,728,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,573,113,430.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,402,418,900.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,402,418,900.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	170,694,530.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	170,694,530.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,750,256,376.00	1,866,934,859.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,750,256,376.00	1,866,934,859.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	951,167,851.92	891,695,048.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	569,910,266.00	666,263,097.06
210101	Үндсэн цалин	350,582,209.00	407,021,300.00
210102	Нэмэгдэл	140,018,874.00	102,009,700.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	52,741,459.00	96,519,907.23
210104	Урамшуулал	26,567,724.00	60,712,189.83
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	140,553,309.00	109,222,200.00

“Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалт хөгжлийн төв”-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210201	Тэтгэврийн даатгалын зардал	117,756,809.00	82,271,000.00
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	5,699,100.00	6,737,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	2,849,500.00	3,369,000.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	2,849,600.00	3,369,000.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	11,398,300.00	13,475,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84,185,399.92	80,291,801.43
210301	Гэрэл, цахилгаан	49,347,379.53	48,744,739.50
210302	Түлш, халаалт	14,236,082.13	15,998,982.45
210303	Цэвэр, бохир ус	20,601,938.26	15,548,079.48
2104	Хангамж, бараа материалын зардал	43,177,200.00	19,334,460.00
210401	Бичиг хэрэг	1,904,800.00	385,100.00
210402	Тээвэр, шатахуун	1,962,000.00	408,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	316,800.00	1,984,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,570,370.00	1,275,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	37,423,230.00	15,281,760.00
2105	Нормативт зардал	7,848,000.00	1,846,990.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,848,000.00	1,846,990.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	104,380,177.00	13,948,480.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,510,150.00	9,252,850.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	2,200,000.00
210604	Урсгал засвар	88,870,027.00	2,495,630.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,113,500.00	788,020.00
210803	Даатгалын үйлчилгээ	511,000.00	539,720.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	44,500.00	104,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	558,000.00	144,000.00
212	ТАТААС	716,994,599.96	909,880,975.78
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	716,994,599.96	909,880,975.78
212101	Бусад төрийн өмчит байгууллагад олгох татаас	716,994,599.96	909,880,975.78
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	82,093,924.12	65,358,834.73
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	40,341,153.40
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	40,341,153.40
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	40,341,153.40
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	40,340,253.40
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал\	-	900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,520,312.00	25,017,681.33
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,077,912.00	24,621,681.33
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,442,400.00	396,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	51,573,612.12	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	33,843,693.12	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	17,729,919.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	66,616,404.00	-

“Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалт хөгжлийн төв”-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	66,616,404.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	66,616,404.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	66,616,404.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	66,616,404.00	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(66,616,404.00)	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
99	Хамаарахгүй	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,959,596,819.84	1,637,194,790.20	(979,338,439.06)	6,617,453,170.98
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,959,596,819.84	1,637,194,790.20	(979,338,439.06)	6,617,453,170.98
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(229,791,927.89)	(229,791,927.89)
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,959,596,819.84	1,637,194,790.20	(1,209,130,366.95)	6,387,661,243.09
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,959,596,819.84	1,637,194,790.20	(1,209,130,366.95)	6,387,661,243.09
19	Тайлант үеийн үр дүн	-	-	3,019,352,150.12	3,019,352,150.12
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,959,596,819.84	1,637,194,790.20	1,810,221,783.17	9,407,013,393.21

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,051,859,800.00	1,808,865,705.60	242,994,094.40	88.2
12	Татварын бус орлого	2,051,859,800.00	1,808,865,705.60	242,994,094.40	88.2
120	Нийтлэг татварын бус орлого	360,000,000.00	214,983,859.00	145,016,141.00	59.7
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	360,000,000.00	214,983,859.00	145,016,141.00	59.7
122	Тусламжийн орлого	1,691,859,800.00	1,593,881,846.60	97,977,953.40	94.2
122005	Төсвөөс санхүүжих	1,691,859,800.00	1,593,881,846.60	97,977,953.40	94.2
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,051,859,800.00	1,808,865,705.60	242,994,094.40	88.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,051,859,800.00	1,808,865,705.60	242,994,094.40	88.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	925,473,000.00	873,967,048.49	51,505,951.51	94.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	672,219,600.00	666,263,097.06	5,956,502.94	99.1
210101	Үндсэн цалин	407,021,300.00	407,021,300.00	-	100.0
210102	Нэмэгдэл	100,160,600.00	102,009,700.00	(1,849,100.00)	101.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	99,571,700.00	96,519,907.23	3,051,792.77	96.9
210104	Урамшуулал	65,466,000.00	60,712,189.83	4,753,810.17	92.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	109,222,200.00	109,222,200.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	82,271,000.00	82,271,000.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	6,737,700.00	6,737,700.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,369,000.00	3,369,000.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,369,000.00	3,369,000.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	13,475,500.00	13,475,500.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	113,243,000.00	80,291,801.43	32,951,198.57	70.9
210301	Гэрэл, цахилгаан	70,697,500.00	48,744,739.50	21,952,760.50	68.9
210302	Түлш, халаалт	22,001,600.00	15,998,982.45	6,002,617.55	72.7
210303	Цэвэр, бохир ус	20,543,900.00	15,548,079.48	4,995,820.52	75.7
2104	Хангамж, бараа материалын зардал	10,739,200.00	9,334,460.00	1,404,740.00	86.9
210401	Бичиг хэрэг	385,100.00	385,100.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	408,600.00	408,600.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,544,400.00	1,984,000.00	560,400.00	78.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,029,900.00	1,275,000.00	754,900.00	62.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,371,200.00	5,281,760.00	89,440.00	98.3
2105	Нормативт зардал	7,039,000.00	1,846,990.00	5,192,010.00	26.2
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,039,000.00	1,846,990.00	5,192,010.00	26.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,150,900.00	6,220,480.00	1,930,420.00	76.3
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,524,900.00	1,524,850.00	50.00	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,130,400.00	2,200,000.00	1,930,400.00	53.3

“Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалт хөгжлийн төв”-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210604	Урсгал засвар	2,495,600.00	2,495,630.00	(30.00)	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,859,100.00	788,020.00	4,071,080.00	16.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,687,700.00	-	2,687,700.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	1,190,600.00	539,720.00	650,880.00	45.3
210804	Тээврийн хэрэгслийн татвар	104,300.00	104,300.00	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	35,800.00	-	35,800.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	724,900.00	144,000.00	580,900.00	19.9
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	115,800.00	-	115,800.00	-
212	ТАТААС	1,056,328,700.00	909,880,975.78	146,447,724.22	86.1
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	1,056,328,700.00	909,880,975.78	146,447,724.22	86.1
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	1,056,328,700.00	909,880,975.78	146,447,724.22	86.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,058,100.00	25,017,681.33	45,040,418.67	35.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	70,058,100.00	25,017,681.33	45,040,418.67	35.7
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	69,662,100.00	24,621,681.33	45,040,418.67	35.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	396,000.00	396,000.00	-	100.0
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	-	-	-
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-	-	-
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	-	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	55	53	2	96.4
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	27	27	-	100.0
620001	Удирдах ажилтан	2	2	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	13	13	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	12	12	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25	25	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	25	25	-	100.0
66	НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	3	1	2	33.3
660001	Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	3	1	2	33.3

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН		17,728,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		17,728,900.00
122	Тусламжийн орлого		17,728,900.00
1221	Хандив тусламж /дотоод/		17,728,900.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого		17,728,900.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		17,728,900.00
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		17,728,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		17,728,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		17,728,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		10,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		10,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		7,728,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		7,728,000.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ		900.00
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		(900.00)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт		(900.00)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт, хөгжлийн төв нь харааны бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангаж, сурган хөгжүүлэх зорилготой, төрийн санхүүжилттэй үйлдвэрийн газар юм.

Тус төв нь дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Үүнд:

- Хараагүй иргэдийн онцлог, ур чадварт тохирсон үйлчилгээ эрхлэх
- Хараагүй иргэдийн хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, хөгжлийг дэмжих сургалт зохион байгуулах
- Тогтвортой ажлын байраар хангах, хөдөлмөрт бэлтгэх, мэргэжил, дадлага эзэмшүүлэх
- Бусад байгууллагад хараагүй иргэдийн асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө, тусламж үзүүлэх

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт, хөгжлийн төв нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц, Нийгмийн халамжийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төрийн ба орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль зэрэг эрх зүйн актыг мөрдлөг болгодог,

Байгууллагын үйл ажиллагаанд мөрддөг хууль тогтоомж, бодлого чиглэлд тайлант хугацаанд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5 дах хэсэгт 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт орсон;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон;
- Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаал “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам” шинэчлэн батлагдсан;
- Сангийн сайдын 2025 оны 12 дугаар сарын 30-ны 240 дүгээр “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ыг шинэчлэн батлах тухай тушаал;
- Сангийн сайдын 2025 оны 6 дугаар сарын 27-ны А/112 дугаар “Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай” тушаал;
- Сангийн сайдын 2025 оны 09 дүгээр сарын 29-ний А/172 дугаар “Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тушаал;
- Тушаалын хасралтанд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Монгол улсын шадар сайдын 2025 оны 05 дугаар сарын 02-ний 71 дүгээр тушаал;

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт, хөгжлийн төв 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 14 зорилтын хүрээнд 57 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгаснаас биелэлтийг хэрэгжилтийн дундаж хувь 85.1 гэж дүгнэгдсэн байгаа тул дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт, хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2021 оноос эхлэн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа боловч санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байгууллагын даргын тушаал шийдвэр гараагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалт хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааны бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,019,352.1 мянган төгрөгөөр буюу 32.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөгөөр/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	64,243.6	36,551.9	(27,691.7)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	116,497.6	202,724.6	86,227.0
Үндсэн хөрөнгө	6,206,920.0	9,167,736.9	2,960,816.9
Нийт хөрөнгө	6,387,661.2	9,407,013.4	3,019,352.2
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	6,387,661.2	9,407,013.4	3,019,352.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,387,661.2	9,407,013.4	3,019,352.2

Тайлант онд нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, Засгийн газрын хувь оролцоо дансдууд байна. Үүнд:

- Авлагын дансны үлдэгдэл 36,551.9 мянган төгрөг болж 27,691.7 мянган төгрөгөөр буурсан нь олон жил болсон насжилт ихтэй авлагуудыг эзэн холбогдогчийг тогтоож барагдуулсантай холбоотой.
- Бараа материал дансны үлдэгдэл 202,724.6 мянган төгрөг болж 86,227.0 мянган төгрөгөөр өссөн нь ГБХНХЯ-ны захиалгаар нийлүүлэгдсэн бараа материалын орлого хүлээн авснаас шалтгаалжээ.
- Үндсэн хөрөнгийн данс 9,167,736.8 мянган төгрөг болж 2,960,816.8 мянган төгрөгөөр өссөн нь улсын төсвөөс санхүүжсэн ГБХНХЯ-ны захиалгаар 1,220,112.9 мянган төгрөгийн их засвар, 1,937,873.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 195,720.4 мянган төгрөгийн компьютер техник хэрэгсэл, нийт 3,353,707.1 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой.
- Засгийн газрын хувь оролцоо данс нь тайлант оны үр дүн 3,019,352.15 мянган төгрөгөөр өсч, Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 9,407,013.39 мянган төгрөг болсон.

Тус байгууллагын программ хангамжийн дансанд бүртгэлтэй 2011 онд худалдан авч, ашиглаж байгаа 225.0 мянган төгрөгийн өртөгтэй санхүүгийн программ хангамж байна. Тайлант онд программ хангамж хөгжүүлэхтэй холбоотой зардал гараагүй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,582,483.5 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны орлогоос 180,000.0

мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,762,483.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 533,061.4 мянган төгрөгөөр бууруулж, 2,229,422.1 мянган төгрөгөөр баталсан байна

Тайлант оны батлагдсан төсөвт тодотгол хийж 271,134.6 мянган төгрөгөөр бууруулж, 1,958,287.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,598,287.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 360,000.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр оны эцэст төсвийн зохицуулалт хийж батлагдсан төсвийг 93,572.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, улсын төсвөөс 1,634,222.1 мянган төгрөг, үйл ажиллагааны орлого 214,983.8 мянган төгрөг, нийт 1,849,205.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,808,865.7 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 40,340.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,808,865.7 мянган төгрөг буюу 88.2 хувьтай байгаа нь цалин ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын шимтгэл 58,720.8 мянган төгрөг, байр ашиглалтын зардал 32,951.2 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 1,404.7 мянган төгрөг, нормативт зардал 21,431.0 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 5,789.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 4,071.1 мянган төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг дэмжих зардал 53,585.3 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлыг 45,040.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувь/
1	72206-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгаалал	2,051,859.8	1,808,865.7	242,994.1	88.2
1.1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	925,473.0	873,967.0	51,506.0	94.4
1.2	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	70,058.1	25,017.7	45,040.4	35.7
1.3	82602-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг дэмжих	1,056,328.7	909,881.0	146,447.7	86.1

Хөтөлбөр, арга хэмжээнд зориулсан зарцуулахаар төлөвлөсөн төсвийн гүйцэтгэл 88.2 хувийн биелэлтэй байна.

Монгол Улсын Ерөнхий аудитораас баталсан “Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад тус байгууллагаас дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ. Үүнд:

1. Тайлант онд 93 орон тооны цалингийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 77 орон тоогоор ажилласан байна. Тус байгууллага нь тайлант онд байдлаар тэтгэвэрт 1 хүн гарсан, хавсарсан ажил гүйцэтгүүлж байгаа 5 орон тоо, 2 хүн хүүхэд асрах чөлөөтэй, чөлөөтэй 3 ажилтан байгаа ба нэмж хүн ажиллуулаагүй байна.
2. Тайлант онд захирлын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Б/01 дугаар тушаалаар унаа, хоолны тарифыг 13.0 мянган төгрөгөөр тогтоож тайлант хугацаанд 96,519.9 мянган төгрөгийн хоол, унааны хөнгөлөлт олгосон.
3. Гадаад томилолт, арга хэмжээний зардал гараагүй, хэвлэл, мэдээллийн байгууллагаар гүйцэтгүүлэх гэрээт ажил хийгдээгүй, төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд өмнөх оны давсан орлогын авлагаас 17,728.9 мянган төгрөг орж, 7,728.00 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 10,000.00 мянган төгрөгийг түүхий эд бараа материал худалдан авч зарцуулж, 0.9 мянган төгрөгийг улсын төсөв төвлөрүүлсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт, хөгжлийн төв нь тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр 164,379.3 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 5 худалдан авах ажиллагаа зохион байгуулахаас 50,400.0 мянган төгрөгийн харуул хамгаалалтын үйлчилгээг харьцуулалтын аргаар, 113,979.3 мянган төгрөгийн түүхий эд материал, урсгал засвар зэргийг шууд худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт, хөгжлийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитыг “Пийк ОМ Аудит” ХХК-ийн ахлах аудитор А.Мөнхцэцэг, аудитор Я.Батбаяр нар гүйцэтгэж, захирал Б.Жаргалсайхан анхан шатны хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитын аудитор С.Болортуяа, аудитын менежер А.Цогбаяр, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт, хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн 2,009,781.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 20,097.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайланд хугацаанд 171 мэдээллийг хуулийн хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны III улирлын санхүүгийн тайланг хамруулж, бараа материал, үндсэн хөрөнгийн дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар 107,106.9 мянган төгрөгийн 4 алдааг залруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 64,243.6 мянган төгрөгийн албан шаардлага, 53,548.9 мянган төгрөгийн 5 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	64,243.6	1	64,243.6	100.0
Зөвлөмж	6	53,548.9	5	-	83.3
Нийт дүн	7	117,792.5	6	64,243.6	85.7

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар худалдан авах ажиллагаатай холбоотой зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй тул тайлант онд албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудалд анхаарлаа хандуулж аудитын горим сорил хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу санхүүгийн тайланг иж бүрэн, үнэн зөв, тодруулгуудын хамт бэлтгэж байгаа эсэх;

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн газрын даргын 2024 оны Б/75 дугаар тушаалаар Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалт хөгжлийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийг томилсоноос одоог хүртэл тус төвийн даргын сонгон шалгаруулалтыг зарлаж явуулаагүй тухай;

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 73,398.9 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснээс аудитын явцад 73,398.9 мянган төгрөгийн 2 алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

- Хэвтэн эмчлүүлэгчийн ор хоногийн төлбөрийн орлогыг мөнгөн сууриар бүртгэснээс тайлант оны 2,234.1 мянган төгрөгийн орлого болон авлагыг дутуу бүртгэсэн байна.
- Бараа материалын тодруулга үр дүнгийн тайлангаас 71,164.8 мянган төгрөгийн зөрүүтэй байна.

Эдгээр алдаанууд нь УСННБОУС-24 Санхүүгийн тайлан дахь Төсвийн мэдээллийн тодруулга, “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Иж бүрэн байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа тул Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу залруулав.

Аудитаар нийт 97,288.9 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд, 68,347.8 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 27,940.7 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 97,288.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 76,190.7 мянган төгрөгөөр давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

5.2 Албан шаардлага

1. Илрүүлэлт: Тайлант онд 62,042.4 мянган төгрөгийн түүхий эд материалын шууд худалдан авалт хийж, өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 “Захиалагч дараах үндэслэлээр аж ахуй эрхлэгчдийн дунд хэлэлцээ хийх замаар гэрээ шууд байгуулж болно”, 35.1.1 “Захиалагч урьдчилан мэдэх боломжгүй нөхцөл байдлын улмаас бараа, ажил, үйлчилгээ худалдан авах яаралтай хэрэгцээ үүссэн шалтгаанаар энэ хуульд заасан бусад аргаар тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй. Тайлбар: Энэ заалтын дагуу гэрээ шууд байгуулахад өмнөх тендер шалгаруулалт амжилтгүй болсон, захиалагчаас хамаарах шалтгаанаар худалдан авах ажиллагаа удааширсан,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

эсхүл төсвийн жил дуусаж санхүүжилтийн эх үүсвэргүй болох нөхцөл байдал хамаарахгүй,” 41 дүгээр зүйлийн 41.1 "Худалдан авах гэрээ дараах нөхцөлийн аль нэгд хамаарах бол илт хууль бус байна", 41.1 "Энэ хуулийг зөрчиж гэрээ шууд байгуулсан", 44 дүгээр зүйлийн 44.1 "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2 дугаар бүлгийн 2.2 "Захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу явуулаагүй өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

2. Илрүүлэлт: Тус байгууллагын захирлын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн Б/14 дугаартай тушаалаар санхүүгийн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогчийг өөрийн чиг үүрэгт нь шууд харьяалагдаж, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллах үүрэг бүхий тооцооны нягтлан бодогчийн албан тушаалыг давхар гүйцэтгүүлж, хавсран ажилласны нэмэгдэл цалинд 5,342.4 мянган төгрөгийн цалин олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.11 “Ерөнхий нягтлан бодогч нь өөрийн шууд удирдлагын доор ажиллаж байгаа нягтлан бодогчдын ажлын гүйцэтгэлийг хянах үүрэгтэй ...”, Захирлын тушаалаар баталсан “Ерөнхий нягтлан бодогчийн албан тушаалын тодорхойлолт”-ын 2 дугаар зорилтын 2-д заасан 7.”Нягтлан бодогчийн үдэж хавтасласан анхан шатны баримтын бүрдэлтийг шалгаж, архивт шилжүүлэх” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хяналт тавих үүрэг бүхий албан тушаалтнаар гүйцэтгэх чиг үүргийн ажлыг давхар гүйцэтгүүлсэн зөрчлийг таслан зогсоож, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

3. Илрүүлэлт: Өмнөх онуудад үүссэн бэлтгэн нийлүүлэгчээс авах 963.0 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 “Хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “Ерөнхий нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэгтэй” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Олон жилийн насжилттай авлагыг барагдуулаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд технологийн хоцрогдолд орсон, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдахгүй байгаа утаагүй зуух, хэвний машин, будагний машин гэх зэрэг 4 нэр төрлийн 10 ширхэг 4,316.5 мянган төгрөгийн хөрөнгүүдийг өмнөх онуудад бэлтгэж бүртгэлд тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.1.3 "Үр ашигтай байх" гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ашиглагдахгүй байгаа хөрөнгөнд элэгдэл тооцож, байгууллагын үр дүнг буруу илэрхийлэхгүй байх, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, хэрэгцээт газарт нь шилжүүлэх хүсэлт холбогдох газарт уламжлах

2. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Ашиглалтын шаардлага хангахгүй, технологийн хоцрогдолд орсон цаашид байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдахгүй үнэ цэнэгүй болсон 5 нэр төрлийн /разетка, потрон, сонсголын аппарат, торгон хэвлэлийн төхөөрөмж/ нийт 23,624.2 мянган төгрөгийн хөрөнгүүд бараа материалын дансанд бүртгэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.5 “Эвдэрсэн, гэмтсэн, чанар байдлаа алдсанаас хэрэгцээнд тохирохгүй болсон тухайн үеийн зах зээлийн үнийн жишгээс хэт өндөр үнээр авсан, хэт доогуур үнээр борлуулсан үндсэн хөрөнгө, түүхий эд, бараа материалын үнэ бүхий зүйлийн жагсаалтыг илрүүлж гэм буруутай хүмүүсээр төлүүлэх буюу данснаас хасуулах тухай саналаа тавих” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн тооллогыг үр дүнтэй хийж, чанар байдлыг үнэлэн, тооллогын үр дүнг тухай бүр шийдвэрлэж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Хэвтэн эмчлүүлэгчийн ор хоногийн төлбөрийн орлогыг мөнгөн сууриар бүртгэснээс тайлант оны 2,234.1 мянган төгрөгийн орлого болон авлагыг дутуу бүртгэсэн байна.	1	2,234.1			1	2,234.1	1	2,234.1				
2	Бараа материалын тодруулга үр дүнгийн тайлангаас 71,164.8 мянган төгрөгийн зөрүүтэй байна.	1	71,164.8			1	71,164.8	1	71,164.8				
Дүн		2	73,398.9			2	73,398.9	2	73,398.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тайлант онд 62,042,4 мянган төгрөгийн түүхий эд материалын шууд худалдан авалт хийж, өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй	1	62,042.4			1	62,042.4						
2	Тус байгууллагын захирлын тушаалаар санхүүгийн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогчын чиг үүрэгт нь шууд харьяалагдаж, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллах үүрэг бүхий тооцооны нягтлан бодогчийн албан тушаалыг давхар гүйцэтгүүлж, хавсран ажилласны нэмэгдэл цалинд 5,342.4 мянган төгрөгийн цалин олгосон.	1	5,342.4			1	5,342.4						
3	Өмнөх онуудад үүссэн бэлтгэн нийлүүлэгчээс авах 963.0 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй.	1	963.0			1	963.0						
4	Үндсэн хөрөнгийн дансанд технологийн хоцрогдолд орсон, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдахгүй 4,316.5 мянган төгрөгийн хөрөнгүүдийг өмнөх онуудад бэлтгэж бүртгэлд тусгасан байна.	1	4,316.5					1	4,316.5				
5	Ашиглалтын шаардлага хангахгүй, үнэ цэнэгүй 23,624.2 мянган төгрөгийн хөрөнгүүд бараа материалын дансанд бүртгэлтэй байна	1	23,624.2					1	23,624.2				
Дүн		5	97,288.5			3	68,347.8	2	27,940.7				-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 314/АД150169

Улаанбаатар хот

САГ-2026/255/НА-СТА-ТЦЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалт хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 62,042,400.00 (Жаран хоёр сая дөчин хоёр мянга дөрвөн зуун) төгрөгийн түүхий эд материалын шууд худалдан авалт хийж, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д "Захиалагч дараах үндэслэлээр аж ахуй эрхлэгчдийн дунд хэлэлцээ хийх замаар гэрээ шууд байгуулж болно", 35.1.1-д "Захиалагч урьдчилан мэдэх боломжгүй нөхцөл байдлын улмаас бараа, ажил, үйлчилгээ худалдан авах яаралтай хэрэгцээ үүссэн шалтгаанаар энэ хуульд заасан бусад аргаар тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй. Тайлбар: Энэ заалтын дагуу гэрээ шууд байгуулахад өмнөх тендер шалгаруулалт амжилтгүй болсон, захиалагчаас хамаарах шалтгаанаар худалдан авах ажиллагаа удааширсан, эсхүл төсвийн жил дуусаж санхүүжилтийн эх үүсвэргүй болох нөхцөл байдал хамаарахгүй," 41 дүгээр зүйлийн 41.1-д "Худалдан авах гэрээ дараах нөхцөлийн аль нэгд хамаарах бол илт хууль бус байна", 41.1-д "Энэ хуулийг зөрчиж гэрээ шууд байгуулсан", 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2 дугаар бүлгийн 2.2 "Захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авалтыг хуулийн дагуу явуулаагүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалт хөгжлийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /З.Лхагвасүрэн/, нягтлан бодогч /Г.Шүрэнцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

З. М.
А. Цогбаяр

Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
А.МӨНХЦЭЦЭГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 315/А015 0169

Улаанбаатар хот

САГ-2026/255/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалт хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх онуудад үүссэн бэлтгэн нийлүүлэгчээс авах 963,000.00 /Есөн зуун жаран гурван мянган/ төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Ерөнхий нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэгтэй" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.7 "Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Олон жилийн насжилттай авлагыг барагдуулаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалт хөгжлийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /З.Лхагвасүрэн/, нягтлан бодогч /Г.Шүрэнцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
А.МӨНХЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 316/А0150169

Улаанбаатар хот

САГ-2026/255/НА-СТА-ТЦЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалт хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын захирлын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн Б/14 дугаартай тушаалаар санхүүгийн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогчийг чиг үүрэгт нь шууд харьяалагдаж, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллах үүрэг бүхий тооцооны нягтлан бодогчийн албан тушаалыг давхар гүйцэтгүүлж, хавсран ажилласны нэмэгдэл цалинд 5,342,400.00 /Таван сая гурван зуун дөчин хоёр мянга дөрвөн зуун/ төгрөгийн цалин олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.11-т "Ерөнхий нягтлан бодогч нь өөрийн шууд удирдлагын доор ажиллаж байгаа нягтлан бодогчдын ажлын гүйцэтгэлийг хянах үүрэгтэй ...", Захирлын тушаалаар баталсан "Ерөнхий нягтлан бодогчийн албан тушаалын тодорхойлолт"-ын 2 дугаар зорилтын 2-д заасан 7."Нягтлан бодогчийн үдэж хавтасласан анхан шатны баримтын бүрдэлтийг шалгаж, архивт шилжүүлэх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хяналт тавих үүрэг бүхий албан тушаалтнаар гүйцэтгэх чиг үүргийн ажлыг давхар гүйцэтгүүлсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалт хөгжлийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /З.Лхагвасүрэн/, нягтлан бодогч /Г.Шүрэнцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
А.МӨНХЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

ATA16037
9025021611

Z:\Alban Shaardlaga\2026\0125.SAG-50.Docx